

БАЯН ЖАНЖИН ХИШИГ АУДИТ ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/165/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаангом хот  
2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,  
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь  
Утас: 70453317, Цахим хаяг: [BatsuuriM@audit.gov.mn](mailto:BatsuuriM@audit.gov.mn)  
Аудитын менежер: М.Бат-Амгалан  
Утас: 70453799, Цахим хаяг: [Bat-Amgalanm@audit.gov.mn](mailto:Bat-Amgalanm@audit.gov.mn)  
Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн Баян жанжин хишиг аудит  
ХХК-ийн туслах аудитор: Б.Төртүвшин  
Утас: 95669092, Цахим хаяг: [baunjanjinxishig@gmail.com](mailto:baunjanjinxishig@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	<b>Error! Bookmark not defined.</b>
Дүгнэлтийн үндэслэл .....	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	3
Аудитын гол асуудал .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	12
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ТШЗ	Төсвийн шүүд захирагч
НА	Нийцлийн аудит



ӨЛГИЙ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Б. ШИНЭТУЯА ТАНАА

**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

2026-02-02 №УВН-2026/165/НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын Цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын Цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсон санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050337

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн заагийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**  
**2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>231,320,312.94</b>	<b>115,750,925.73</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	184,619,947.94	72,391,935.73
<b>312</b>	Банкинд байгаа бэлэн мөнгө	184,619,947.94	72,391,935.73
<b>3121</b>	Төгрөг	184,619,947.94	72,391,935.73
31211	Төрийн сангийн харилцах	184,619,947.94	72,391,935.73
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	46,700,365.00	43,358,990.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	46,700,365.00	43,358,990.00
35410	Бичиг хэргийн материал	2,146,200.00	2,146,200.00
35420	Аж ахуйн материал	9,202,540.00	9,499,540.00
35440	Түлш, шатах тослох материал	764,000.00	00.00
35460	Хүнсний материал	4,997,625.00	2,123,250.00
35470	Бусад хангамжийн материал	29,590,000.00	29,590,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>721,637,263.66</b>	<b>692,269,324.68</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	721,637,263.66	692,269,324.68
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	710,496,263.50	681,155,824.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	760,754,666.30	760,754,666.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	-123,433,168.85	-148,053,784.73
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	50,450,630.00	57,950,630.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-22,877,728.41	-31,322,244.08
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,202,535.00	51,242,535.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,726,562.12	-26,677,911.42
39214	Бусад үндсэн хөрөнгө	32,968,124.20	30,886,718.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	-16,540,832.62	-15,323,384.77
39217	Ном	1,698,600.00	1,698,600.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	11,141,000.16	11,113,500.18
39301	Програм хангамж	575,000.00	575,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-519,999.84	-547,499.82
39303	Бусад биет бус хөрөнгө	11,086,000.00	11,086,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>952,957,576.60</b>	<b>808,020,250.41</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>5,535,200.00</b>	<b>00.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	5,535,200.00	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	5,535,200.00	00.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	5,535,200.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	5,535,200.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>947,422,376.60</b>	<b>808,020,250.41</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	947,422,376.60	808,020,250.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	154,533,993.20	154,533,993.20
51101	Өмч: - төрийн	154,533,993.20	154,533,993.20
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	511,959,894.16	372,557,767.97

51210	Өмнөх үеийн үр дүн	511,959,894.16	511,959,894.16
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-139,402,126.19
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	280,928,489.24	280,928,489.24
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>952,957,576.60</b>	<b>808,020,250.41</b>

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>796,841,438.85</b>	<b>663,272,633.08</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>13,800,000.00</b>	<b>19,015,333.08</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>13,800,000.00</b>	<b>19,015,333.08</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	10,365,333.08
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,123,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	7,242,133.08
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>783,041,438.85</b>	<b>644,257,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>740,085,300.00</b>	<b>609,072,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	740,085,300.00	609,072,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>42,956,138.85</b>	<b>35,184,800.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,956,138.85	35,184,800.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>707,222,608.82</b>	<b>802,674,759.27</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>707,222,608.82</b>	<b>802,674,759.27</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>700,928,608.82</b>	<b>802,624,759.27</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>467,852,993.85</b>	<b>567,145,979.00</b>
210101	Үндсэн цалин	302,247,141.32	344,181,991.00
210102	Нэмэгдэл	145,171,453.00	186,260,342.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	16,852,250.00
210104	Урамшуулал	20,434,399.53	19,851,396.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчдоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>58,805,114.20</b>	<b>71,484,513.21</b>
210201	Тэтгэврийн даатгал	39,764,225.78	46,284,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,687,820.55	5,445,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,633,511.50	6,026,192.75
210204	Ажилгүйдлийн даатгал	2,343,910.70	2,843,920.46
210205	Эрүүл мэндийн даатгал	9,375,645.67	10,883,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>40,692,138.85</b>	<b>41,076,933.08</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,251,138.85	4,376,077.08
210302	Түлш, халаалт	37,441,000.00	36,700,856.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>27,076,895.00</b>	<b>8,422,850.00</b>
210401	Бичиг хэрэг	8,938,050.00	1,727,850.00
210402	Тээвэр, шатахуун	2,672,050.00	3,093,800.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,466,795.00	3,601,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>59,431,945.00</b>	<b>63,354,245.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	112,900.00
210502	Хоол, хүнс	59,431,945.00	63,241,345.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,500,000.00</b>	<b>1,300,000.00</b>
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,300,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>982,000.00</b>	<b>1,190,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	982,000.00	1,190,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,750,000.00</b>	<b>1,475,000.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,750,000.00	1,475,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>42,837,521.92</b>	<b>47,175,238.98</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,581,590.00	3,045,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	6,111,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,255,931.92	38,017,938.98
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,294,000.00</b>	<b>50,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>6,294,000.00</b>	<b>00.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,294,000.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>50,000.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	50,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>89,618,830.03</b>	<b>-139,402,126.19</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>89,618,830.03</b>	<b>-139,402,126.19</b>

### 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>783,041,438.85</b>	<b>647,380,500.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>3,123,200.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>00.00</b>	<b>3,123,200.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	3,123,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,123,200.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>783,041,438.85</b>	<b>644,257,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>740,085,300.00</b>	<b>609,072,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	740,085,300.00	609,072,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>42,956,138.85</b>	<b>35,184,800.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,956,138.85	35,184,800.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>651,912,386.90</b>	<b>759,608,512.21</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>651,912,386.90</b>	<b>759,608,512.21</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>645,618,386.90</b>	<b>759,558,512.21</b>

<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	467,658,507.03	570,569,292.21
210101	Үндсэн цалин	300,692,383.03	347,605,304.21
210102	Нэмэгдэл	144,571,982.00	185,760,342.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	17,352,250.00
210104	Урамшуулал	22,394,142.00	19,851,396.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	58,999,601.02	68,061,200.00
210201	Тэтгэврийн даатгал	39,867,554.75	46,284,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,690,300.75	5,445,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,634,751.55	2,723,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,345,150.75	2,723,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,461,843.22	10,883,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	41,456,138.85	33,834,800.00
210301	Гэрэл, цахилгаан	3,251,138.85	8,698,209.08
210302	Түлш, халаалт	38,205,000.00	25,136,590.92
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	52,194,450.00	60,366,970.00
210502	Хоол, хүнс	52,194,450.00	60,366,970.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,500,000.00	1,300,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,300,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,750,000.00	1,475,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,750,000.00	1,475,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	22,059,690.00	23,951,250.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,706,740.00	17,839,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,352,950.00	6,111,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,294,000.00</b>	<b>50,000.00</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	00.00	00.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	6,294,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,294,000.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	00.00	50,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	50,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>131,129,051.95</b>	<b>-112,228,012.21</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>3,389,800.00</b>	<b>00.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,389,800.00</b>	<b>00.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>3,389,800.00</b>	<b>00.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,389,800.00	00.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-3,389,800.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	127,739,251.95	-112,228,012.21
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	56,880,695.99	184,619,947.94

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	184,619,947.94	72,391,935.73
----	---	----------------	---------------

#### 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/				
		Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	154,533,993.20	280,928,489.24	348,153,168.75	00.00	783,615,651.19
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	154,533,993.20	280,928,489.24	348,153,168.75	00.00	783,615,651.19
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	16,889,188.27	00.00	16,889,188.27
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	154,533,993.20	280,928,489.24	511,959,894.16	00.00	947,422,376.60
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	154,533,993.20	280,928,489.24	511,959,894.16	00.00	947,422,376.60
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	154,533,993.20	280,928,489.24	511,959,894.16	00.00	947,422,376.60
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00

D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-139,402,126.19	00.00	-139,402,126.19
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	154,533,993.20	280,928,489.24	372,557,767.97	00.00	808,020,250.41

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	762,435,200.00	724,423,712.21
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	762,435,200.00	724,423,712.21
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	762,435,200.00	724,423,712.21
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	596,448,700.00	570,569,292.21
210101	Үндсэн цалин	391,374,600.00	347,605,304.21
210102	Нэмэгдэл	192,002,000.00	185,760,342.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	17,352,250.00
210104	Урамшуулал	13,072,100.00	19,851,396.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	74,275,200.00	68,061,200.00
210201	Тэтгэврийн даатгал	50,417,300.00	46,284,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,964,500.00	5,445,700.00
210203	ҮОМЦӨ-ний даатгал	2,982,200.00	2,723,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,982,200.00	2,723,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,929,000.00	10,883,800.00
2105	<b>Нормативт зардал</b>	60,674,500.00	60,366,970.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	00.00
210502	Хоол, хүнс	60,674,500.00	60,366,970.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,572,000.00	1,475,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,572,000.00	1,475,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	27464800.00	23951250.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,353,200.00	17,839,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,111,600.00	6,111,600.00

	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	792,436,747.94	612,195,700.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	613,836,100.00	609,072,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	613,836,100.00	609,072,500.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	178,600,647.94	3,123,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,123,200.00	3,123,200.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	175,477,447.94	00.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	184,619,947.94
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	72,391,935.73
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	19.50	19.50
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	11.50	11.50
620003	Үйлчлэх ажилтан	7.00	7.00

## 2.6 АУДИТ ХИЙСЭН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	/төгрөгөөр/	
				Гүйцэтгэл зөрүү	Хувь
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>35,184,800.00</b>	<b>35,134,800.00</b>	<b>50,000.00</b>	<b>99.9%</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>35,184,800.00</b>	<b>35,134,800.00</b>	<b>50,000.00</b>	<b>99.9%</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>35,184,800.00</b>	<b>35,134,800.00</b>	<b>50,000.00</b>	<b>99.9%</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>33,834,800.00</b>	<b>33,834,800.00</b>		<b>100%</b>
210301	Гэрэл цахилгаан	5,765,800.00	8,698,209.08	-2,932,409.08	150%
210302	Түлш, халаалт	27,771,100.00	25,136,590.92	2,634,509.08	90.5%
210303	Цэвэр, бохир ус	297,900.00		297,900.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,350,000.00</b>	<b>1,300,000.00</b>	<b>50,000.00</b>	<b>96.3%</b>
210604	Урсгал засвар	1,350,000.00	1,300,000.00	50,000.00	96.3%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>35,184,800.00</b>	<b>35,134,800.00</b>	<b>50,000.00</b>	<b>99.9%</b>
<b>1310</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>35,184,800.00</b>	<b>35,134,800.00</b>	<b>50,000.00</b>	<b>99.9%</b>

132001	Орон нутгийн төсвөөс	35,184,800.00	35,134,800.00	50,000.00	99.9%
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>19.50</b>	<b>19.50</b>		<b>100%</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00		100%
620002	Гүйцэтгэх ажилтан	11.50	11.50		100%
620003	Үйлчлэх ажилтан	7.00	7.00		100%

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сургуулийн өмнөх болосролын зорилго, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, хүүхдийг асрах, хамгаалах, тэдний хөгжил, төлөвшлийг дэмжсэн цогц үйл ажиллагаа эрхлэх СӨБ-ын сургалтын орчны стандартыг хэрэгжүүлэх, хүүхдийн бүтээлч сэтгэхүйг дэмжин хөгжүүлэх сургалтын ая тухтай орчин бүрдүүлэх, багш ажилтны ажлын байрны тасралтгүй хөгжлийг дэмжих, эцэг эх, асран хамгаалагчдын олон нийтийн оролцоо дэмжлэгийг нэмэгдүүлэх.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Өлгий сумын Цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд

- Боловсролын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ хадалдан авах тухай хууль
- Хэмнэлтийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Нийгмийн даатгалын ерөнхий хууль 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдсөн
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр, 05 дугаар сарын 04-ний өдөр, 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 11 дүгээр сарын 10-ны өдөр, 12 дугаар сарын 07-ны өдөр, 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр
- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны 3 дугаар тогтоолоор улссын хэмжээнд мөрдөх

хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн бараа ажил үйлчилгээ худалда авах тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр тус тус шинэчлэн тогтоосон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 144,937.4 мянган төгрөгөөр буюу 15,3 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	184,619.9	72,391.9	112,228.0
Авлага	0.00	0.00	0.00
Бараа материал	46,700.4	43,358.9	-3,341.5
Үндсэн хөрөнгө	721,637.3	692,269.3	-29,368.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>952,957.6</b>	<b>808,020.2</b>	<b>-144,937.4</b>
Өр төлбөр	5,535.2	0.00	-5,535.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	947,422.3	808,020.2	- 139,402.1
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>952,957.6</b>	<b>808,020.2</b>	<b>-144,937.4</b>

Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл нь өмнөх оны үзүүлэлтээс 112,228.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 43,358.9 мянган төгрөг болж 3,341.5 мянган төгрөгөөр буурчээ. Бараа материал дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 692,269.3 мянган төгрөг болж, 29,368.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардал өссөнтэй холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 808,020.2 мянган төгрөг болж 139,402.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн нөлөөлсөн байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 700,433.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 91,360.8 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 609,072.5 мянга, орон нутгийн төсвөөс 35,184.8 мянга, нийт 644,257.3 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төсөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 609,072.5 мянга, урьд оны үлдэгдлээс санхүүжих 175,477.4 мянга, туслах үйл ажиллагааны орлого 3,123.2 мянга нийт 787,673.1 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд 724,423.7 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд эны эхний үлдэгдлээс 9,142.5 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна.

Орон нутгийн төсвөөс 35,134.8 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлж гэрэл цахилгааны зардалд 8,698.2 мянга, түлш халаалын зардалд 25,136.6 мянга, урсгал засварын зардалд 1,300.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 759.558.4 мянган төгрөг буюу 95.2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 25,879.4 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 6,214.0 мянга, нормативт зардлыг 307.5 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 3,513.5 мянга, мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

#### **Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл**

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Цэцэрлэгийн хүүхийн хоол	66,289.0	60,366.9	5,922.0	91%

2	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,412.0	2,412.0	0.00	100%
3	Боловсролын байгууллагын багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	2,118.4	1,060.5	325.6	50%
4	Боловсролын стандарт сургалтын орчин	656,874.6	646,401.8	10,472.7	98.%
5	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	7,015.6	6,859.7	155.9	97.8%
6	Эрүүл мэндийг дэмжих	1,337.5	1,045.0	128.2	78.1%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамж	-	-	Байгууллагын үйл ажиллагаанд 575.0 мянган төгрөгийн программ ашиглаж байна.
2	Унаа,хоолны зардал	-	16,852.2	2025 онд унаа, хоолны зардалын төсөв гэж төсөвлөөгүй бөгөөд цалингийн зардалаас 16,852.2 мянган төгрөг олгосон.
3	Сургалт ,семинар	-	-	Тухайн байгууллагад төсөвлөгдсөн зардал байхгүй .
4	Гадаад томилолт,арга хэмжээ	-	-	Гадаад томилолтын зардал гараагүй
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	-	-	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Хэвлэл мэдээлэл	-	-	Тайлант жилд хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ хийгээгүй.
7	Орон тоо	596,448.7	570,596.3	Өлгий сумын Цэцэрлэг нь 2025 онд 19.5 орон тоотой үйл ажиллагаа явуулж 596,448.7 мянган төгрөгийн цалингийн зардал батлагдсанаас тайлант онд 570,569.3 мянган төгрөгийг ажилчдын цалин хөлс,урамшуулалд зарцуулсан байна.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Өлгий сумын Хүүхдийн цэцэрлэг нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлага гараагүй байна.

### **3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Өлгий сумын Цэцэрлэгийн тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Өлгий сумын Цэцэрлэгийн 2025 онд 60,474.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй хүүхдийн хоолны тендерийг нээлттэйгээр харьцуулалтын арга ашиглан 7 багцаар зохион ХДЭЧББ ххк, Цэсбод ххк, иргэн Д.Анхбаяр нартай гэрээ байгуулж худалдан авалт хийжээ.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын Цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян жанжин хишиг аудит ХХК-ийн туслах аудитор Б.Төртүвшин гүйцэтгэж, хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Батсүх, аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян жанжин хишиг аудит ХХК-д 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 556,724.5 мянган төгрөгөөс 1 хувиар

буюу 5,567.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 802,674.7 мянган төгрөгийн 1 хувиар буюу 8,026.7 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 6,421.4 мянган төгрөгөөр тогтоолоо.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Өлгий сумын Цэцэрлэгийн хувьд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 163, хугацаа хоцроож 6 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өлгий сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 585.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 1,253,198.0 мянган төгрөгийн албан шаардлага өгсөн биелэлтийг бүрэн хангаж 2025 оны 04 сарын 25-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өлгий сумын Цэцэрлэгийн хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн 3,670.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

#### 5.1 Төлбөрийн акт

##### Илрүүлэлт:

Өлгий сумын Цэцэрлэг нь балансын урамшууллын цалинг давхардуулан олгосон зөрчил илэрлээ.

Цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/23 дугаар “Урамшуулалт цалин олгох тухай” тушаалаар нягтлан бодогч Д.Дуламсүрэнд 3,118.0 мянга, нярав М.Бумжидад 552.5 мянга, нийт 3,670.5 төгрөгийн балансын урамшуулалт цалин олгожээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.1 дэх заалтад “Төсвийн байгууллага, төрийн орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3 -д “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Төрийн албаны тухай хуулийн 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.3 дахь заалтад “Хуульд нийцээгүй шийдвэр гаргах”, гэж заасныг зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Балансын урамшуулалын цалинг давхардуулан олгосон нягтлан бодогч Д.Дуламсүрэнд 3,118.0 мянга, 0.5 сарын балансын урамшуулалт цалин 552.5 мянга, нийт 3,670.5 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

Дээрх төлбөрийн актыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 25 ны өдрийн дотор ирүүлнэ үү

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан		Запруулаагүй		Тоо	Дүн

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Давхардуулан олгосон балансын урамшуулалт цалин	1	3,670.5	1	3,670.5									
Дүн	1	3,670.5	1	3,670.5									

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

## АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



/М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: БАЯН ЖАНЖИН ХИШИГ АУДИТ  
ХХК-ийн ТУСЛАХ АУДИТОР

/Б.ТӨРТҮВШИН/

2026 оны 02 дугаар сарын 02 ны өдөр



## УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 01/17/24825440  
УВА-2026/165/НА-СТА-ТШЗ

Улаангом

### Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Увс аймгийн Өлгий сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Увс аймгийн Өлгий сумын Цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/23 дугаар тушаалаар нягтлан бодогч Д.Дуламсүрэнд давхардуулан олгосон 3,118.0 мянга, нярав М.Бумжидад 1.5 сарын цалингаас илүү олгосон 552.5 мянга, нийт 3.670.5 мянган төгрөгийн урамшуулалт цалинг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1 дэх заалтад “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3 дахь хэсэгт “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Төрийн албаны тухай хуулийн 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.3 дахь заалтад “Хуульд нийцээгүй шийдвэр гаргах”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 3.3-д “Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна” гэж заасныг хэрэгжүүлж ажилаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах

<sup>1</sup>Увс аймаг, Улаангом сум, 3 дугаар баг, Ө.Бадрахын гудамж, аймгийн Засаг Даргын Тамгын газрын байр, 304 тоот, Утас: 70453317

8525110039

нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.3 дахь заалтад “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон”, 4.2.3.8 дахь заалтад “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Илүү бөгөөд давхардуулан олгосон балансын урамшуулалт цалин /Гурван сая зургаан зуун далан мянган таван зуу/ 3,670.5 мянган төгрөгийг Цэцэрлэгийн эрхлэгч Б.Шинэтуяа, нягтлан бодогч Д.Дуламсүрэн нараар төлүүлж МХГ-ын орлогын 100150000982 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 05 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Увс аймгийн Өлгий сумын Цэцэрлэгийн эрхлэгч Б.Шинэтуяа, нягтлан бодогч Д.Дуламсүрэн нарт хариуцуулав.
3. Төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

БАЯН ЖАНЖИН ХИШИГ АУДИТ  
АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ТӨРТҮВШИН

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ